

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/07/НА-СТА-ЗГТС

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он | Санхүү-нийцлийн газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Ч.Болд Утас: 51-260512 Цахим хаяг: boldch@audit.gov.mn Ахлах аудитор: С.Бат-Эрдэнэ Утас: 51-261628 Цахим хаяг: Bat-Erdenes@audit.gov.mn Аудитор: П.Ариунзаяа Утас: 51-261628 Цахим хаяг: Ariunzayap@audit.gov.mn |
|---|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН ДАРГА Я.ЭРДЭНЭСАЙХАН
ТАНАА

2024.03.25 № 07/845
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь шинж чанарын хувьд материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 27,312.5 сая төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байгаа нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох журамтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын оршин байх, үнэлгээ, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

ХХААХҮС-ын 2022 оны А/384 дүгээр “Чиглэл өгөх тухай” тушаалаар 2023 онд орон нутагт хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлж Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдэд орон нутагт бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, төвлөрлийг сааруулах зорилгоор ЖДҮХС-аас олгох хөнгөлөлттэй зээлийн 30.0 хувийг Нийслэлд, 70.0 хувийг орон нутагт олгохоор чиглэл өгсөн байна.

Дээрх чиглэлийн дагуу МУЗГ-ын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан журам болон ХААХҮС-ын 2023 оны А/37, А/458, А/326, А/512 дугаар тушаалуудаар батлагдсан хөнгөлөлттэй зээл олгох "Ерөнхий нөхцөл", гуравласан гэрээний дагуу 9 удаа зээл зарлаж, нийт 820 төслийн хүсэлт ирснээс 265 төсөлд 35,628.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Аудитын гол асуудал

Шууд зээлийн авлагын үлдэгдэл 108,743.5 сая төгрөгөөс тайлант хугацаанд 9,370.2 сая төгрөгийн авлагыг барагдуулж, оны эцэст шууд зээлийн 58.0 хувь буюу 99,373.3 сая төгрөгийн 347 зээлдэгчээс авах авлага "муу зээл"-ийн ангилалд бүртгэлтэй хэвээр байна.

Бусад асуудлын хэсэг

ЖДҮХС-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 41 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, 86.83 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------|--|---------------------------|---------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 258,254,585,498.81 | 272,416,457,000.98 |
| 33 | АВЛАГА | 257,166,355,548.81 | 271,621,199,050.98 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 6,553,043,611.06 | 16,296,420,298.19 |
| 33500 | Бусад авлага | 275,561,632.21 | 573,858,829.54 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 144,479,845.21 | 339,876,642.54 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 131,081,787.00 | 233,982,187.00 |
| 33600 | Зээлийн авлага | 250,337,750,305.54 | 254,750,919,923.25 |
| 33610 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага | 250,337,750,305.54 | 254,750,919,923.25 |
| 33615 | Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл | 250,337,750,305.54 | 254,750,919,923.25 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 1,088,229,950.00 | 795,257,950.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 387,172,000.00 | 94,200,000.00 |
| 35400 | Хангамжийн материал | 701,057,950.00 | 701,057,950.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 701,057,950.00 | 701,057,950.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 258,254,585,498.81 | 272,416,457,000.98 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 7,177,169,367.61 | 17,546,803,790.13 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 731,919,867.61 | 612,371,554.15 |
| 41300 | Өглөг | 568,694,666.00 | 406,694,666.00 |
| 41360 | Бусад өглөг | 568,694,666.00 | 406,694,666.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 568,694,666.00 | 406,694,666.00 |
| 41400 | Урьдчилж орсон орлого | 163,225,201.61 | 205,676,888.15 |
| 41440 | Бусад урьдчилж орсон орлого | 163,225,201.61 | 205,676,888.15 |
| 42 | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 6,445,249,500.00 | 16,934,432,235.98 |
| 42200 | Урт хугацаат зээл | 6,445,249,500.00 | 16,934,432,235.98 |
| 42210 | Төгрөг | 6,445,249,500.00 | 16,934,432,235.98 |
| 42217 | Санхүүгийн бусад байгууллага | 6,445,249,500.00 | 16,934,432,235.98 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 251,077,416,131.20 | 254,869,653,210.85 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 251,077,416,131.20 | 254,869,653,210.85 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 251,077,416,131.20 | 254,869,653,210.85 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 238,388,264,528.53 | 251,077,416,131.20 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 12,689,151,602.67 | 3,792,237,079.65 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 258,254,585,498.81 | 272,416,457,000.98 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---------------|--|--------------------------|-------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 14,313,340,114.90 | 6,269,982,794.14 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 14,313,340,114.90 | 6,269,982,794.14 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 14,313,340,114.90 | 6,269,982,794.14 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 13,712,282,164.90 | 6,269,982,794.14 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,292,805,526.46 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 226,292,145.67 | 4,130,364,680.51 |
| 1200046 | Зээлийн хүүгийн орлого | 11,193,184,492.77 | 2,139,618,113.63 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 601,057,950.00 | - |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,624,188,512.23 | 2,477,745,714.49 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,624,188,512.23 | 2,477,745,714.49 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,552,329,700.00 | 2,438,517,579.38 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,552,329,700.00 | 2,438,517,579.38 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,552,329,700.00 | 2,438,517,579.38 |
| 211 | ХҮҮ | 71,858,812.23 | 39,228,135.11 |
| 2112 | Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр | 71,858,812.23 | 39,228,135.11 |
| 211201 | Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр | 71,858,812.23 | 39,228,135.11 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 12,689,151,602.67 | 3,792,237,079.65 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 12,689,151,602.67 | 3,792,237,079.65 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---------------|---|----------------------------|----------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 42,166,953,551.64 | 51,925,229,441.30 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 27,602,046,123.28 | 51,925,229,441.30 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 27,602,046,123.28 | 51,925,229,441.30 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 27,602,046,123.28 | 51,925,229,441.30 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 27,602,046,123.28 | 51,925,229,441.30 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 14,564,907,428.36 | - |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 14,564,907,428.36 | - |
| 131004 | Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх | 14,564,907,428.36 | - |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 8,105,373,311.06 | 16,296,420,298.19 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 8,105,373,311.06 | 16,296,420,298.19 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,552,329,700.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,552,329,700.00 | - |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,552,329,700.00 | - |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 6,553,043,611.06 | 16,296,420,298.19 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 6,553,043,611.06 | 16,296,420,298.19 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,553,043,611.06 | 16,296,420,298.19 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 34,061,580,240.58 | 35,628,809,143.11 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | (34,061,580,240.59) | (35,628,809,143.11) |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 19,496,672,812.23 | 35,628,809,143.11 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 19,496,672,812.23 | 35,628,809,143.11 |
| 24 | ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР | 14,564,907,428.36 | - |
| 240001 | Гадаад зээлийн үндсэн төлбөр | - | - |
| 241001 | Засгийн газрын бондын үндсэн төлбөр | 14,564,907,428.36 | - |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | (0.01) | - |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.01 | - |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|--------------------|--|
| 1 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | - | - | 238,592,751,343.77 | 238,592,751,343.77 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - | 238,388,264,528.53 | 238,388,264,528.53 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (204,486,815.24) | (204,486,815.24) |
| 9 | Тайлант үеийн үр дүн | - | - | 12,689,151,602.67 | 12,689,151,602.67 |
| 11 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | - | - | 251,077,416,131.20 | 251,077,416,131.20 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - | 251,077,416,131.20 | 251,077,416,131.20 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | 3,792,237,079.65 | 3,792,237,079.65 |
| 20 | 2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | - | - | 254,869,653,210.85 | 254,869,653,210.85 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэл зөрүү | Хувь |
|--------|---|-------------------|-----------------------------|--------------------|-------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 50,000,000,000.00 | 35,628,809,143.11 | 14,371,190,856.89 | 71.3 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 50,000,000,000.00 | 35,628,809,143.11 | 14,371,190,856.89 | 71.3 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 50,000,000,000.00 | 35,628,809,143.11 | 14,371,190,856.89 | 71.3 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 50,000,000,000.00 | 51,925,229,441.30 | (1,925,229,441.30) | 103.9 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 50,000,000,000.00 | 51,925,229,441.30 | (1,925,229,441.30) | 103.9 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 50,000,000,000.00 | 51,925,229,441.30 | (1,925,229,441.30) | 103.9 |

3. АУДИТЫН ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 557.4 сая төгрөгийн 2 алдаа илэрснийг санхүүгийн тайланд бүрэн залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|--------------------------------------|------------|-----------|-----------------------------------|----------|--------------------------|-----------|------------|-----------|--------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан | 1 | 533,431.2 | | | 1 | 533,431.2 | 1 | 533,431.2 | | | | |
| Жижиг, дунд үйлдвэрийн газар | 1 | 23,940.0 | 1 | 23,940.0 | | | 1 | 23,940.0 | | | | |
| Дүн | 2 | 557,371.2 | 1 | 23,940.0 | 1 | 533,431.2 | 2 | 557,371.2 | - | - | - | - |

Аудитаар нийт 27,312.5 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 26,534.7 сая төгрөгийн 7 албан шаардлага хүргүүлж, 777.9 сая төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | |
|------------------|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|--------------------------------------|---------------------|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо |

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | | | | | | | | | | |
|--------------------------------------|----|--------------|--|---|--------------|---|-----------|---|---|---|---|
| Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан | 7 | 27,239,919.3 | | 5 | 26,507,062.5 | 2 | 732,856.8 | | | | |
| Жижиг, дунд үйлдвэрийн газар | 5 | 72,609.1 | | 2 | 27,609.1 | 3 | 45,000.0 | | | | |
| Дүн | 12 | 27,312,528.4 | | 7 | 26,534,671.6 | 5 | 777,856.8 | - | - | - | - |

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн асуудлаар нийт 22,322.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж, түүнд 4 албан шаардлага, 1 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|--|-------------|--------------|-----------------|--------------|---------|-----|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | |
| Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан | 1 | 18,333,370.3 | 1 | 18,333,370.3 | | |
| Жижиг, дунд үйлдвэрийн газар | 1 | 3,287,777.8 | 1 | 3,287,777.8 | | |
| Дүн | 2 | 21,621,148.1 | 2 | 21,621,148.1 | - | - |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | |
| Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан | 1 | 701,058.0 | 1 | 701,058.0 | | |
| Жижиг, дунд үйлдвэрийн газар | 2 | - | 1 | - | 1 | - |
| Дүн | 3 | 701,058.0 | 2 | 701,058.0 | 1 | - |
| Нийт дүн | 5 | 22,322,206.1 | 4 | 22,322,206.1 | 1 | - |